



**БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 8 сарын 21

№ 255

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын "Хүүхдийн төлөө төв" байгуулах тухай

БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдийн төлөө үндэсний төв"-ийн дүрмийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас **ТОГТООХ** нь:

1. Нийслэлийн хэмжээнд хүүхдийн талаар явуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулах үүрэг бүхий Улаанбаатар хотын "Хүүхдийн төлөө төв"-ийг байгуулсугай.

2. Улаанбаатар хотын "Хүүхдийн төлөө төв"-ийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. "Хүүхдийн төлөө төв"-ийн тогтвортой мөрдөх сарын цалингийн санг 148,2 мянган төгрөгөөр тогтоосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

[Handwritten signature]
Л.ЭНЭБИШ

[Handwritten signature]
Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны 1991 оны
43 дугаар тогтоолын хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ
ТӨВИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэргэд Хүүхдийн төлөө төв нь Улаанбаатар хотод хүүхдийн талаар төр, захиргааны байгууллагаас явуулах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах зохицуулах, хүүхдийн олон нийтийн болон үүсгэл санаачилгын байгууллагыг нийгмийн харилцаанд төлөөлөн, удирдлага, арга зүйгээр хангах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

2. Тус төв нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын хууль, тогтоол, хотын Ардын Хурлын Тэргүүдэгчид, түүний гүйцэтгэх захиргаанаас гаргасан тогтоол, захирамж, Боловсролын сайдын болон Хүүхдийн төлөө үндэсний төвийн даргын тушаал, заавар, энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

3. Хүүхдийн төлөө төв нь хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, Хүүхдийн төлөө үндэсний төвийн удирдлагын дор ажиллана.

4. Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас томилогдсон дарга Хүүхдийн төлөө төвийг удирдаж ажиллах бөгөөд төвийн дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж биелэлтийг хангуулна.

5. Хүүхдийн төлөө төвийн даргын зөвлөлийг төвийн даргын тушаалаар байгуулна.

6. Төвийн дэргэд хүүхдийн боловсрол, хүмүүжил, эрүүл мэнд, биеийн тамир, хууль хяналт зэрэг асуудлаар холбогдох байгууллагын удирдах ажилтны бүрэлдэхүүнтэй хүүхдийн асуудал эрхэлсэн зөвлөл ажиллана. Түүний бүрэлдэхүүнийг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа батална.

7. Дүүргийн дэргэд хүүхдийн асуудал эрхэлсэн зөвлөл ажиллана.

8. Хотын дүүргүүдийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэргэд Хүүхдийн асуудал эрхэлсэн зохион байгуулагчид ажиллана.

224

2.

9. Хүүхдийн төлөө төв нь тогтоосон журмын дагуухийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас харагдэнэ.

ХОЁР. Хүүхдийн төлөө төвийн үүрэг

1. Улаанбаатар хотын хэмжээнд 0-18 насны хүүхдийн талаар явуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, зохицуулах, Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Хүүхдийн эрхийн тухай" конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавих

2. Дүүргийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас хүүхдийн талаар явуулж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж, зохих удирдлагаар хангах.

3. Хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай зохион байгуулах, тэднийг амьдрал хөдөлмөрт бэлтгэх, өсвөр үеийнхэнд хүнлэг энэрэнгүй үзэл төлөвшүүлэх, үндэсний түүх соёл, зан заншлаа эзэмшүүлж, байгаль орчноо хайрлан хамгаалж зөв зохистой ашиглаж сургахад сургууль, хүүхдийн хөдөлмөр, соёл, хүмүүшлийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, нэгдсэн удирдлагаар хангах

4. Эрүүл мэнд, бие бэлдрын хэвийн өсөлт, боловсрол, ёс суртахуунд нь үл харшлах хэлбэрээр хүүхдийн хөдөлмөрийг зохион байгуулах, хөдөлмөр хамтгалал, хөдөлмөрийн хөлсийг нь баталгаажуулах талаар хотын хэмжээнд холбогдох байгууллагатай хамтран бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

5. Хүүхдэд зориулсан уран бүтээл, хэвлэл нийтлэл, мэдээлэл сурталчилгааны бодлогыг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлэх

6. Өнчин, тахир дутуу, оюуны хомсдолтой болон амьдралын гачигдалтай хүүхдийг асран хамгаалах, тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах

7. Хүүхдийн эрх ашиг хөндсөн асуудлаар улс, хоршоолол олон нийтийн болон хувийн үйлдвэр, компани байгууллагуудад зөвлөлгөө чиглэл өгөх, хамтран ажиллах

3.

8. Хүүхдийн төлөө олон нийтийн үүсгэл санаачилга, байгууллага, хөдөлгөөнийг бүх талаар дэмжин хөгжүүлэх

9. Хүүхдийн төлөө төвийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж шийдвэрлэх

10. Хүүхдийн ахуй, нас, хүйс, сэтгэхүйн онолог, сонирхол, эрэлт харагчээг онолын үндэслэлтэй судлан дүгнэлт хийж, нийгмийн сөрөг үзэгдлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах,

11. Хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хөрөнгө оруулалт, төсвийн оновчтой бодлого явуулах, хүүхдийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх

12. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, байгууллага иргэдээс хандив өргүүлэх ажлыг зохион байгуулах зэргээр өөрийн байгууллагыг санхүүжүүлэх хөрөнгийн намагдэл эх үүсвэр бий болгох арга хэмжээ авах.

13. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хөдөлмөрчдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх

ГУРАВ. Хүүхдийн төлөө төвийн эрх

1. Хүүхдийн эрх ашиг хөндсөн асуудлаар

нутаг давсгарийн аж ахуйн нэгж байгууллагын ажлыг шалгаж тэдгээрийн удирдах ажилтан мөргөжилтний илтгэл сонголыг авч хэдэлцэх, үүрэг даалгавар өгч биелэлтийг нь хангуулах

2. Хүүхдийн байгууллагын арга хэмжээнд хотын төсвөөс олгосон хөрөнгийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулна.

3. Анхан шатны байгууллагын хүүхдийн асуудал эрхэлсэн зөвлөгч-арга зүйчдийг томилж, удирдлагаар хангана.

4. Хотын хэмжээнд хүүхдийн эрх ашиг, эрхэлсэн ажлын холбогдолтой мэдээ, материалыг холбогдох улс, хоршоолол, олон нийтийн байгууллага болон хувийн үйлдвэр байгууллагуудаас гаргуулан авна.

4.

5. Хүүхдийн эрх ашгийг хохироосон үйл ажиллагаа явуулсан буюу тогтоол шийдвэр гаргасан тохиолдолд түүнийг өөрчлүүлэх, хүчингүй болгуулах буюу арга хэмжээ оногдуулах саналаа холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлдэг.

6. Хүүхдийн төлөө үйлсэд идэвхи зүтгэл гаргасан, тавьяа байгуулсан хүмүүс, шуларга үйлс бүтээсэн хүүхэд хамт олныг шагнаж урамшуулах ба дээд байгууллагад тодорхойлно.

7. Гадаад орнуудын хүүхдийн байгууллага, хөдөлгөөн, төвтэй харилцах, хамтран ажиллах талаар бие даасан үйл ажиллагаа явуулна.